



ЯАРАЛТАЙ

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 7а, Утас: 26 21 35,
Факс: (976-11) 32 21 27, E-mail: info@mfa.gov.mn,
<http://www.mfa.gov.mn>

2017.03.03 № 10/1294
танай _____-ны № _____-т

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Д.МӨРӨН ТАНАА


2017 оны 4 дүгээр сараас эхлэн БНСУ хилийн урьдчилан шалгах систем /I-Prechecking/-ийг нэвтрүүлэхтэй холбогдуулан 2017 оны 3 дугаар сарын 1-нээс эхлэн БНСУ-ын виз олгох журамдаа нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан БНСУ-ын ЭСЯ-ны зөвлөхтэй хийсэн уулзалтын ярианы тэмдэглэл, солонгосын талаас гардуулсан ноотыг хавсралтаар хүргүүлэв.

Хүлээн авч танилцан, холбогдох арга хэмжээ авахыг хүсье.

Хавсралт: Ярианы тэмдэглэл, ноот 14 хуудас.

КОНСУЛЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ

Я.АРИУНБОЛД



MMG 96/2017

Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам Монгол Улсын Гадаад харилцааны яаманд хүндэтгэлээ илэрхийлэхийн ялдамд, манай улс руу визгүй зорчдог гадаадын иргэдийн талаар дараах өөрчлөлт орсныг үүгээр мэдэгдэх завшаан тохиов.

БНСУ-ын Засгийн Газраас 2017.04.01-ний өдрөөс эхлэх Солонгос руу нислэг үйлддэг дотоод, гадаадын бүх агаарын тээврийн компаниудад хамаарах "онгоцонд суухаас өмнө визийг шалгах хөтөлбөр"-ийг амжилттай нэвтрүүлэхийн тулд энэ оны 3-р сарын 1-ний өдрөөс байнгын визгүй зорчигчдын талаар визгүй зорчих журамд зарим өөрчлөлт оруулан хэрэгжүүлж эхлэхээр болоод байна.

Өөрчлөлт орсон гол зүйл бол өмнө нь визгүй зорчих нөхцлийг хангаж визгүй зорчдог болсон гадаадын иргэдэд 5 жилийн олон удаагийн виз(оршин суух хугацаа 30 хоног) олгохоор болсон юм. Уг өөрчлөлт нь манай улсад визгүй зорчих гэрээтэй улс орнуудаас бусад буюу Монгол шиг визтэй зорчдог улсын иргэдэд үйлчлэх бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийн талаар хавсралт материалтай танилцахыг хүсье.

Энэ завшааныг тохиолдуулан Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам Монгол Улсын Гадаад харилцааны яаманд нэн өндөр хүндэтгэлээ дахин илэрхийлж байна.

Хавсралт : Дэлгэрэнгүй мэдээлэл

2017 оны 2-р сарын "23"-ны өдөр,
Улаанбаатар хот

Хувийг : Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харъяатын газар,
Зам, тээврийн хөгжлийн яам, Иргэний нисэхийн ерөнхий газар

Шинэчилсэн визний журам (визгүй зорчих журмыг өөрчилсөн)

БНСУ-ын Засгийн Газраас 2017 оны 3-р сарын 1-ний өдрөөс эхлэн шинэчилсэн визний журмыг хэрэгжүүлэх тул виз мэдүүлэгч иргэд дараах зүйлд анхаарал хандуулахыг хүсье.

1. Байнгын визгүй зорчдог байсан иргэд олон удаагийн виз авдаг болно.

- Визгүй зорчих нөхцлийг хангаж визгүйгээр зорчдог байсан иргэдэд олон удаагийн виз олгоно.(Өөрөөр хэлбэл визгүй зорчих ойлголт үгүй болж оронд нь олон удаагийн виз авдаг болно)

Байнгын визгүй зорчигч гэдэг нь сүүлийн 2 жилийн дотор 4 буюу түүнээс дээш удаа, эсвэл нийт 10 буюу түүнээс дээш удаа Солонгосын хилээр орсон хүнийг хэлнэ.(Сүүлийн 2 жилийн дотор дор хаяж 1 удаа хилээр орсон тамга заавал байх)

- Урьд нь журамд байгаагүй заалт болох сүүлийн 2 жилийн дотор дор хаяж 1 удаа хилээр орсон тамга заавал байх хэрэгтэйг анхаарна уу.
- Шинэ журам хэрэгжиж эхэлсэнээр визгүй зорчих журам хүчингүй болно.

Виз мэдүүлэх газар : БНСУ-ын ЭСЯ-ны виз мэдүүлгийн төлөөлөн гүйцэтгэх байгууллага

Визний төрөл : Богино хугацааны энгийн виз(С-3-1), 30 хоног, 5 жилийн олон удаагийн виз, хураамжгүй

Байнгын визгүй зорчдог хүний хувьд олон удаагийн визний болзлыг хангах бөгөөд

- 1) Дээрх “Богино хугацааны энгийн виз(С-3-1), 30 хоног, 5 жилийн олон удаагийн виз, хураамжгүй”-г сонгох юмуу
- 2) Өмнө нь байсан “Богино хугацааны энгийн виз(С-3-1), богино

хугацааны бизнес виз(С-3-4), богино хугацааны аяллын виз(С-3-9) 90 хоног, 1/3/5/ жилийн олон удаагийн виз, хураамжгүй"-г сонгож болно.

ЭСЯ-нд олон удаагийн виз мэдүүлэх нөхцөлд "Сүүлийн 2 жилийн дотор 4 буюу түүнээс дээш удаа, эсвэл нийт 10 буюу түүнээс дээш удаа Солонгосын хилээр орсон, Солонгосын хууль тогтоомжийг зөрчиж байгаагүй хүн" хамрагдаж байгаа болно.

Виз мэдүүлэх нөхцөл :

Сүүлийн 2 жилийн дотор 4 буюу түүнээс дээш удаа, эсвэл нийт 10 буюу түүнээс дээш удаа Солонгосын хилээр орсон хүн (Сүүлийн 2 жилийн дотор дор хаяж 1 удаа хилээр орсон тамга заавал байх)

- Урьд нь журамд байгаагүй заалт болох сүүлийн 2 жилийн дотор дор хаяж 1 удаа хилээр орсон тамга заавал байх хэрэгтэйг анхаарна уу.

Харин виз мэдүүлсэн өдрөөс урагш 3 жилийн дотор хууль бусаар оршин суусан юмуу Солонгосын бусад хууль тогтоомж зөрчиж 5 сая воноос дээш торгууль хүлээсэн, албадан гаргагдсан хүн хамрагдахгүй юм.

Дээрх нөхцлийн дагуу олон удаагийн виз авсан хүн визний хугацаандаа хууль бусаар оршин суух зэрэг Солонгосын хууль тогтоомж зөрчиж "виз мэдүүлэх эрхгүй болсон тохиолдолд визийг хүчингүй болгож өөрт нь мэдэгдэнэ.(хилээр гарах сануулгаас бусад)

Хилээр нэвтэрсэн тоог хэрхэн тооцоолох вэ? Гадаадын иргэний үнэмлэх авч бүртгүүлсэн хүний хилээр удаа дараа орсон тоо, Чэжү арал руу визгүйгээр нэвтэрсэн тоо, хил дээрээс өөр онгоц сольж суусан хүний мэдээллийг тооцож оруулах боловч, гэрээгээр ажиллах(Е-9), далайн хөлөг дээр ажиллах(Е-10) зэрэг хууль бусаар оршин суух магадлал өндөртэй бизийн хүчний ажил хийдэг гадаадын иргэний бүртгэлтэй хүний хилээр удаа дараа орсон тоог тооцож оруулахгүй болно.

2. Гуравдагч улсаар дайран өнгөрч Солонгост ирсэн Монгол иргэнийг визгүй нэвтрүүлнэ.

↳ - Гуравдагч улсаар дайран өнгөрч Солонгост ирсэн Монгол иргэнийг визгүй нэвтрүүлэх болсон.

↳ - Нислэгийн чиглэл: Өмнө нь Монголоос Солонгос руу шууд нислэгээр ирэхэд визгүй нэвтрүүлдэг байсан бол шинэ журмаар гуравдагч улсаар дайран өнгөрсөн нислэгээр Солонгост ирсэн тохиолдолд бас визгүй нэвтрүүлнэ.

↳ - Улсын тоог нэмнэ : Өмнө нь Европын 8 улс байсныг Европын 30 улс болгож нэмнэ.

○ 1) Европын 30 улсаас аль нэг улсын визтэй(байнгын оршин суух үнэмлэх мөн хамаарна) хүн Солонгосоор дайран өнгөрч нэр заасан Европын 30 улс руу явах юмуу 2) дээрх Европын 30 улсаас явах замдаа Солонгосоор дайран өнгөрч өөрийн болон 3-дагч улс руу явж буй хүн

- Уг Европын 30 улс нь : Грек, Нидерланд, Норвеги, Дани, Герман, Литва, Румын, Люксембург, Литвани, Лихтенштейн, Мальт, Бельги, Швед, Швейцари, Испани, Словак, Словени, Исланд, Ирланд, Эстони, Англи, Австри, Итали, Чех, Кипр, Португали, Польш, Франц, Финлянд, Унгар

- Цахим визтэй хүн, паспорт дээр виз наалгасан болон өндөр хөгжилтэй 4 улсаас (Америк, Канад, Австрали, Шинэ Зеланд) зөвхөн өөрийн болон 3-дагч улс руу явж буй тохиолдолд зөвшөөрнө.

↳ - Виз олгох нөхцөл

○ Хилээр орсон өдрөөс урагш 3 жилийн дотор хил дээрээс буцаагдсан, хууль бусаар оршин суусан юмуу Солонгосын бусад хууль тогтоомж зөрчиж 5 сая воноос дээш торгууль хүлээсэн, албадан гаргагдсан тэмдэглэл байхгүй хүн

○ 30 хоногийн дотор хилээр гарах нислэгийн тийзтэй бөгөөд тухайн 3-дагч улсад хууль бусаар оршин суусан зэрэг зөрчилгүй хүн

○ Онгоц сольж суух юмуу дайран өнгөрөхдөө тухайн 3-дагч улсдаа 3 хоногоос доош хугацаагаар оршин суусан хүн

↳ Оршин суух ангилал болон хугацаа: Дамжин өнгөрөх жуулчлал(В-2), 30 хоног